

## МАЛЫН ЭМЧ, МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох, бүртгэх үйл ажиллагааг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.2. Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.1-т заасан байгууллагад ажиллаж байгаа малын эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, ур чадварын хөгжлийн тодорхойлох, үнэлэх, дэмжин урамшуулахад чиглэгдэнэ.

1.3. Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох, бүртгэх үйл ажиллагааг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллах орон тооны бус сургалтын комисс /цаашид “комисс” гэх/ хариуцан зохион байгуулна.

1.4. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.4.1. “Малын эмч” гэж мал эмнэлгийн боловсрол олгох магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийг малын эмч мэргэжлээр төгссөн, мэргэжлээрээ ажиллахад шаардагдах боловсрол, ур чадвар эзэмшсэн хүнийг;

1.4.2. “Мэргэжилтэн” гэж магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг төгссөн, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.1-т заасан байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа бусад мэргэжлийн хүнийг;

1.4.3. “Мэргэшил” гэж өөрийн эзэмшсэн мэргэжлийн дагуу шинжлэх ухааны чиглэлээр магистр, докторын сургалтад хамрагдаж төгссөн, мэдлэг, ур чадвар, дадлага бүхий малын эмч, мэргэжилтэнг;

**Хоёр. Мэргэшлийн зэргийн шатлал, ажилласан хугацааг тооцох**

2.1. Мэргэшлийн зэрэг нь ахлах, тэргүүлэх, зөвлөх гэсэн 3 шатлалтай байна.

2.2. Мэргэшлийн зэргийг тухайн малын эмч, мэргэжилтний боловсрол, мэдлэг, мэргэшсэн байдал, мэргэжлийн онолын түвшин, дадлага туршлага, зохион байгуулах ур чадвар, идэвх санаачилга, бүтээлч сэтгэлгээ, авьяас, чадавхыг шалган тогтоосны үндсэн дээр олгоно.

2.3. Ахлах зэрэгтэй эмч, мэргэжилтэн нь тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан, байгууллагын бусад мэргэжилтэн нарт зөвлөж хамтран ажиллах, тэдний хөгжилд хувь нэмрээ оруулах ур чадвартай байна.

2.4. Тэргүүлэх зэрэгтэй малын эмч, мэргэжилтэн нь тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан, бүс, орон нутгийн мэргэжилтэн нарт зөвлөх, ур чадвартай байна.

2.5. Зөвлөх зэрэгтэй малын эмч, мэргэжилтэн нь тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан, салбар, үндэсний түвшний мэргэжилтэн нарт зөвлөх, ур чадвартай байна.

2.6. Мэргэшлийн зэрэг хооронд шатлал ахиулах хугацаа 5 ба түүнээс дээш жил байна.

2.7. Мэргэшлийн зэргийн шатлалыг алгасуулан олгохгүй.

2.8. Дор дурдсан үндэслэлийг албан ёсны бичиг баримтаар нотолсон тохиолдолд энэхүү журмын 3.1-т заасан мэргэжлээрээ ажилласан жилд оруулж тооцно.

2.8.1 ажиллах хугацаандаа жирэмсний болон амаржсаны амралттай, хууль тогтоомжийн дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацаа;

2.8.2 цэргийн жинхэнэ алба хаасан;

2.8.3 өөрийн болон гэр бүлийн гишүүний биеийн эрүүл мэндийн байдлын улмаас мэргэжлээрээ ажиллахгүйгээр эмчлүүлж, сувилуулсан;

2.8.4 эмнэлгийн шинжилгээ хийлгэсэн, донорын үүрэг гүйцэтгэсэн;

2.8.5 гадаад улсад мэргэжил, мэргэшлээрээ суралцсан, магистр, докторын сургалтад хамрагдсан;

2.8.6 төгсөлтийн дараах мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан;

2.8.7 удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр өөр ажил гүйцэтгэсэн, төрийн байгууллагын сонгуульт ажлыг гурван сар хүртэлх хугацаагаар гүйцэтгэсэн;

2.8.8. төрийн албанд ажиллах үедээ ажлаас үндэслэлгүйгээр халагдсаныг шүүхээр эгүүлэн тогтоосон бол уг шалтгаанаар ажилгүй байсан хугацаа;

2.8.8 олон улсын байгууллага, гадаад улсаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн нэгжид мэргэжил, мэргэшлийн дагуу ажилласан;

2.9. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллагын удирдлага, сургалт, хүний нөөц, үйлчилгээний байгууллагад ажиллаж байгаа малын эмч, мэргэжилтний мэргэшлийн зэргийг хүчинтэйд тооцох ба энэхүү журамд заасны дагуу мэргэшлийн зэргийг давтан хамгаалж, ахиулна.

2.10. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд мэргэшлийн зэрэг олгохгүй.

**Гурав. Мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт.**

3.1.Малын эмч, мэргэжилтэнд тавигдах шаардлага:

| № | Горилж буй мэргэшлийн зэрэг | Мэргэшлийн зэрэг горилоход тавигдах шалгуур үзүүлэлт |
|---|-----------------------------|--|
|---|-----------------------------|--|

|   |           |                   |  |
|---|-----------|-------------------|--|
| 1 | Ахлах     | Нийтлэг шаардлага | Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллеж төгсөж малын эмч болон бусад мэргэжлээр дээд /бакалавр, магистр/ боловсрол эзэмшсэн байх;         |
|   |           | Тусгай шаардлага  | Бакалаврын зэрэгтэй мал эмнэлгийн байгууллагад 8 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх;                          |
| 2 | Тэргүүлэх | Нийтлэг шаардлага | Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллеж төгсөж малын эмч болон бусад мэргэжлээр дээд /бакалавр, магистр, доктор/ боловсрол эзэмшсэн байх; |
|   |           | Тусгай шаардлага  | Бакалаврын зэрэгтэй мал эмнэлгийн байгууллагад 13 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх;                         |

|   |        |                   |   |
|---|--------|-------------------|---|
|   |        | Тусгай шаардлага  | Мал эмнэлгийн салбар шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн, мэргэшлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан байх;<br>Тухайн мэргэшил, мэргэшлээрээ ажилласан сүүлийн 3 жилийн хугацаанд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;  |
| 3 | Зөвлөх | Нийтлэг шаардлага | Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллеж төгсөж малын эмч болон бусад мэргэжлээр дээд /бакалавр, магистр, доктор/ боловсрол эзэмшсэн байх;  |
|   |        |                   | Бакалаврын зэрэгтэй мал эмнэлгийн байгууллагад 25 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх;  |
|   |        | Тусгай шаардлага  | Магистрын зэрэгтэй бол мал эмнэлгийн байгууллагад 15 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх;<br>Мал эмнэлгийн салбар шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн, мэргэшлээрээ 8 ба түүнээс дээш жил ажилласан байх;<br>Тухайн мэргэшил, мэргэшлээрээ ажилласан сүүлийн 5 жилийн хугацаанд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх; |

**Дөрөв. Мэргэшлийн зэрэг горилогчийн бүрдүүлэх баримт бичиг**

4.1. Мэргэшлийн зэрэг горилогч нь дараахь баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлнэ. Үүнд:

- 4.1.1. мэргэшлийн зэрэг олгохыг хүссэн хувийн өргөдөл;
- 4.1.2. иргэний үнэмлэхийн хуулбар эсвэл цахим лавлагаа;
- 4.1.3. харьяалах байгууллагын даргын баталгаажуулсан мэргэшлийн зэрэг горилогчийн бүрэн бөглөсөн маягт (Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталгаажуулсан загвараар)
- 4.1.4. харьяалах аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын дэмжсэн албан бичиг, тодорхойлолт;
- 4.1.5. малын их эмчийн мэргэжлийн дипломын хуулбар /хэрвээ гадаадад боловсрол эзэмшсэн бол баталгаат орчуулгыг нэмж хавсаргах/;
- 4.1.6. 3x4 хэмжээтэй зураг 2 хувь (сүүлийн 6 сард авахуулсан байх);
- 4.1.7. мэргэшлийн зэрэг горилоход тавигдах шаардлагыг хангасныг баталгаажуулсан баримт бичгийн хуулбар;
- 4.1.8. гарын авлага, ном, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, газар зүйн заалт, ашигтай загварын гэрчилгээний хуулбар /*мэргэшлийн зэргийг шалгуур үзүүлэлт харгалзахгүйгээр олгох нөхцөлд*/;
- 4.1.9. дэд профессор, профессорын зэрэг олгосон үнэмлэхийг нотариатаар батлуулсан хуулбар /*мэргэшлийн зэргийг шалгуур үзүүлэлт харгалзахгүйгээр олгох нөхцөлд*/;
- 4.1.10. эрдмийн зэрэг цол хамгаалсан дипломын хуулбар /*мэргэшлийн зэргийг шалгуур үзүүлэлт харгалзахгүйгээр олгох нөхцөлд*/

**Тав. Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт**

5.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах, сургалтын комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

5.1.2. малын эмч, мэргэжилтэний нийгмийн асуудал, урамшуулалын талаар Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулж, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх;

5.1.3. мэргэшлийн зэрэгтэй холбоотой цахим бүртгэлийн мэдээллийн санг ажиллуулах, боловсронгуй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

5.1.4. мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаатай холбоотой журам, заавар, маягт, загвар, арга, аргачлалыг батлаж, мөрдүүлэх;

5.1.5. мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох, бүртгэх шийдвэрийг гаргах, зөвлөх зэргийг олгох талаар эрх бүхий этгээдэд уламжлах;

5.2. Мэргэшлийн зэрэг шинээр олгох, нөхөн олгох, хүчингүй болгох талаар энэ журмын 1.3-т заасан сургалтын комисс нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1. мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах байгууллагыг сонгон шалгаруулж, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргаар батлуулж, цахим санд тухай бүр байршуулах;

5.2.2. мэргэшлийн зэргийн сургалтын батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө болон холбогдох мэдээллийг мал эмнэлгийн хүний нөөцийн хөгжил, удирдлагын систем болон байгууллагын цахимд хуудсанд байршуулах.;

5.2.3. аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллагаас ирүүлсэн мэргэшлийн зэргийн шалгалтад орох малын эмч, мэргэжилтний бичиг баримтыг журмын дагуу хүлээн авч хянаж шийдвэрлэх;

5.2.4. мэргэшлийн зэрэг олгох сургалт, шалгалтыг зохион байгуулах, малын эмч, мэргэжилтнээс мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх;

5.2.5. мэргэшлийн зэрэг олгосон шийдвэрийг үндэслэн мэргэшлийн зэргийн үнэмлэхийг батлагдсан загварын дагуу бичиж, ажлын 5 хоногт багтаан аймаг нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллагуудад албан бичгээр мэдэгдэх;

5.2.6. мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон материал, мэдээлэл бусад холбогдох баримт бичгийг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн санд бүртгэж, архивын нэгж болгон Архивын тухай хууль, тогтоомжид заасан хугацаанд хадгална.

5.3. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.1. мэргэшлийн зэрэг шинээр горилох, шатлал ахиулах хүсэлт ирүүлсэн малын эмч, мэргэжилтний судалгааг жил бүрийн 12 дугаар сарын 10-наас өмнө нэгтгэн гаргах;

5.3.2. тухайн жилд мэргэшлийн зэргийн шалгалт өгөх, шатлал ахиулах малын эмч, мэргэжилтний хүсэлтийг хэлэлцэх, мэргэшлийн зэргийн шалгалтад орох шалгуурыг хангасан зэрэг горилогчийн бичиг баримтын бүрдлийг хангуулан, энэ журмын 5.3.1-д заасан хугацаанд багтаан Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

5.3.3. малын эмч, мэргэжилтнийг мэргэшлийн зэргийн шалгалтын талаарх мэдээллээр хангах, сургалтын байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах;

5.3.4. мэргэшлийн зэргийн сургалт хийх хугацаанд малын эмч, мэргэжилтний үүрэгт ажлыг зохицуулах, дэмжлэг үзүүлэх;

5.3.5. мэргэшлийн зэргийн нэмэгдэлд шаардагдах зардлыг тооцож, жил бүрийн улсын төсөвт тусгуулах;

5.3.6 мэргэшлийн зэрэг олгох тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн малын эмч, мэргэжилтэнд тогтоосон хувь, хэмжээгээр мэргэшлийн зэргийн нэмэгдлийг сар бүр тооцож олгох;

5.4. Сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг нь мэргэшлийн зэргийн чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.4.1. тухайн сум, дүүргийнхээ мэргэшлийн зэрэгтэй болон мэргэшлийн зэрэг горилоч малын эмч, мэргэжилтний судалгаатай байх ба мэргэшлийн зэрэг шинээр горилох, шатлал ахиулах малын эмч, мэргэжилтний хүсэлтийг хүлээн авч бүрдлийг хангуулан, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад уламжлах;

5.4.2. мэргэшлийн зэргийн сургалт, шалгалтын талаар малын эмч, мэргэжилтэнд мэдээлэл хүргэх;

5.4.3. мэргэшлийн зэргийн сургалтад хамрагдах хугацаанд малын эмч, мэргэжилтний хариуцан ажиллаж байгаа үүрэгт ажлыг зохицуулах, дэмжлэг үзүүлэх.

5.5. Малын эмч, мэргэжилтэн нь мэргэшлийн зэргийн чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.5.1. мэргэшлийн зэрэг шинээр горилох, шатлал ахиулах тохиолдолд өөрийн харьяалах байгуулагад энэхүү журмын 4.1-д заасан бичиг баримтын бүрдлийг хангасны үндсэн дээр хүсэлт гаргаж, баталгаажуулах;

5.5.2. бүрдүүлсэн бичиг баримт, нотолгоо, тайлан, хүсэлтийн үнэн зөвийг бүрэн хариуцах;

5.5.3. мэргэшлийн зэргийн сургалттай холбогдон гарах зардлыг хариуцан төлөх.

### **Зургаа. Мэргэшлийн зэрэг олгох сургалт, шалгалтыг зохион байгуулах**

6.1. Ахлах, тэргүүлэх, зөвлөх мэргэшлийн зэргийн сургалт болон шалгалтыг жилд нэг удаа зохион байгуулна.

6.2. Мэргэшлийн зэргийн сургалт зохион байгуулах байршил, хугацаа, сургалтад орох эрх хангасан малын эмч, мэргэжилтний нэрийг сургалт эхлэхээс ажлын 14-өөс доошгүй хоногийн өмнө Мал, амьтны

эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага цахим санд байршуулан горилоччийн харьяалах байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ.

6.3. Мэргэшлийн зэргийн сургалт, шалгалтыг сургалтын эрх бүхий байгууллага болон мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулна.

6.4. Мэргэшлийн “Багц” хичээлүүдээр “Ахлах” мэргэжилтэн 10 багц цаг, “Тэргүүлэх” мэргэжилтэн 20 багц цаг, “Зөвлөх” мэргэжилтэн 30 багц цагийг тус тус судлана.

6.5. Мэргэжлийн зэрэг олгох шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр тухай бүр байгуулна.

6.6. Шалгалтын комиссын гишүүд нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд үүний 3 оос доошгүй гишүүд нь их, дээд сургуулийн багш, мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоодын төлөөлөл байна.

6.7. Мэргэшлийн зэргийн шалгалт дараах үе шаттай явагдана:

6.7.1. шалгалтын бэлтгэл ажлыг хангах, бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах;

6.7.2 шалгалтын комиссыг байгуулах;

6.7.3 шалгалт зохион байгуулах;

6.7.4 шалгалтын гүйцэтгэлийг дүгнэх, мэдээлэх;

6.7.5 шалгалттай холбоотой гомдол шийдвэрлэх;

6.7.6 шийдвэр гаргах.

6.8. Мэргэшлийн зэрэг олгох шалгалт нь ахлах зэрэг горилоччид нэг, зөвлөх болон тэргүүлэх зэрэг горилоччид хоёр хүртэл үе шаттай байна. Үүнд

6.8.1. нэгдүгээр үе шатны шалгалт: мэргэшлийн мэдлэг, ур чадвар, туршлага шалгах;

6.8.2.хоёрдугаар үе шатны шалгалт: салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, журам, зааврын талаарх мэдлэгийг шалгах.

6.9. Ахлах, зөвлөх болон тэргүүлэх зэрэг горилогч нь мэргэшлийн мэдлэг, ур чадварын шалгалтад авбал зохих нийт онооны 80 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн бол тэнцсэнд тооцно.

6.10. Хоёрдугаар шатны шалгалтыг бичгээр эсхүл сорилоор авна.

6.11. Шалгалтын сорилын өгөгдлийг мэдээллийн сангаас шалгалт эхлэхээс 2 цагийн өмнө сонгох бөгөөд нууцлалыг шалгалтын комисс хариуцана.

6.12. Зэрэг горилогч нь эхний шатны шалгаруулалтад тэнцээгүй бол дараагийн шатны шалгаруулалтад орох эрхгүй.

6.13. Шалгалтын комисс нь малын эмч, мэргэжилтний мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадварыг шалгалтаар, туршлагыг ажил байдлын тодорхойлолтоор бүтээлийн тайланг магадлан шалгах замаар тодорхойлно.

6.14. Шалгалтын комиссын гишүүдэд нөлөөлөхийг оролдсон, горилогчийг үндэслэлгүй дэмжиж, бусдаас хэт зөрүүтэй үнэлгээ өгсөн гишүүний саналыг комиссын хурлаар хэлэлцэж, түүний үнэлгээг комиссын нэгдсэн дүнд оруулах эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ.

6.15. Зэрэг горилогчийн авсан онооны нийлбэрийг шалгалтын комиссын нарийн бичгийн дарга нэгтгэн дүгнэж, дундаж оноог гаргах ба комиссын дарга энэ дүнг шалгалтын комиссын гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн гишүүн бүрээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

6.16. Шалгалтын комисс нь сорилын дүнг үндэслэн мэргэшлийн зэрэг олгох эсэх талаарх саналаа сургалтын комисст /Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад/ хүргүүлнэ.

6.17. Шалгалтын комиссын нарийн бичгийн дарга нь энэхүү журмын 6.19-д заасан хугацаанд хүсэлт, гомдлыг хүлээн авч, шалгалт зохион байгуулах комиссын хурлаар шийдвэрлүүлнэ. Шалгалтын комиссын шийдвэр эцсийн шийдвэр байна.

6.18. Мэргэшлийн зэрэг горилогч нь шалгаруулалтад тэнцээгүй бол дахин шалгаруулалтад оролцох хүсэлтээ бичгээр гаргасны үндсэн дээр тухайн жилд зөвхөн нэг удаа дахин шалгаруулалтад орж болно.

6.19. Мэргэшлийн зэргийн шалгалттай холбоотой дараах гомдлыг Малын эмч, мэргэжилтнээс мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулсан комисст бичгээр гаргаж шийдвэрлүүлнэ:

6.19.1 шалгалтын бүртгэлтэй холбоотой гомдол;

6.19.2 комиссын гишүүн журам зөрчсөн тухай гомдол;

6.19.3 шалгалтын явцад гарсан зөрчилтэй холбоотой гомдол;

6.19.4 шалгалтын агуулга, хэлбэртэй холбоотой гомдол;

6.19.5 шалгалтын үнэлгээтэй холбоотой гомдол;

6.19.6 шалгалттай холбоотой бусад гомдол.

6.20. Гомдол гаргагч нь энэхүү журмын 6.19.1-д заасан гомдлыг бүртгэл дууссанаас хойш ажлын 2 хоногт сургалтын комисст, 6.19.3-д заасан гомдлыг шалгалт өгсөнөөс хойш ажлын нэг өдөрт, 6.19.5-д заасан гомдлыг шалгалтын дүнг зарласан өдрийн ажлын цагт багтаан харин 6.19.2, 6.19.4, 6.19.6-д заасан гомдлыг шалгалт дууссанаас хойш ажлын 2 хоногийн дотор шалгалтын комисст тус тус бичгээр ирүүлнэ.

6.21. Гомдол гаргагч нь батлагдсан маягтын дагуу үндэслэлээ тодорхой дурдаж, өөрийнхөө тавьж буй шаардлагын талаарх нотолгоо, бусад холбогдох баримтыг хавсаргана.

6.22. Шалгалтын болон сургалтын комисс нь гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан шалгаж, хариуг гомдол гаргагчид албан бичгээр хүргүүлнэ.

6.23. Гомдол гаргагч нь шалгалтын болон сургалтын комиссын шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд эрх бүхий бусад байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

**Долоо. Мэргэшлийн зэрэг олгох, бүртгэх**

7.1. Энэ журмын 6.15-д заасан саналыг хянан үзэж, сургалтын комиссын гишүүдийн нь 80.0%-иас доошгүй хувийн ирцтэйгээр хуралдаж, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг хэлэлцэж, дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэн протокол үйлдэж Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

7.2. Уг протоколыг үндэслэн Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар “Ахлах”, “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэг олгоно.

7.3. “Зөвлөх” зэрэг олгох тухай Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг хянан үзэж, мэргэшлийн “Зөвлөх” зэргийн үнэмлэх, энгэрийн тэмдэг, хувийн дугаар бүхий тамгыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

7.4. Мал эмнэлгийн салбарын хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан дараахь шалгуурын 3-аас доошгүйг хангасан бол энэ журмын 3.1-т заасан шаардлага хамаарахгүй ба энэ журамд заасан шалгалтгүйгээр мэргэшлийн зөвлөх зэргийг олгоно.

7.4.1. мэргэжлийн дагуу тэргүүлэх зэрэгтэйгээр салбартаа тасралтгүй 10-аас доошгүй жил ажилласан;

7.4.2. мэргэжлийн дагуу тасралтгүй 25 ба түүнээс дээш жил ажилласан мэргэшлийн ахлах зэрэгтэй бол;

7.4.3. салбарын хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн 10-аас доошгүй баримт бичгийг гардан боловсруулж, батлуулсан бол;

7.4.4. салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн 5-аас доошгүй хөтөлбөр, төсөл, боловсруулахад ажлын хэсэгт орж ажиллаж, тухайн бодлогын баримт бичиг батлагдаж, хэрэгжүүлсэн;

7.4.5. мал эмнэлгийн ухааны доктор (ph.D), шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг, профессор цол хүртсэн;

7.4.6. Монгол Улсын Төрийн соёрхол, малын гавьяат эмч, Хөдөлмөрийн баатар цол хүртсэн бол.

7.5. Энэхүү журмын 7.4-т заасан малын эмч, мэргэжилтэн нь хүсэлтээ Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шууд ирүүлнэ.

7.6. Тухайн чиглэлээр мэргэшлийн зэрэг олгосныг гэрчлэх баримт бичиг нь мэргэшлийн зэргийн үнэмлэх байна.

7.7. Малын эмч, мэргэжилтний мэргэшлийн зэрэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрт нэгэн адил хүчинтэй байна.

### **Найм. Мэргэшлийн зэргийг хүчингүй болгох, нөхөн олгох**

8.1. Дараах тохиолдолд малын эмч, мэргэжилтний мэргэшлийн зэргийг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр хүчингүй болгоно:

8.1.1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.13 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь тогтоогдсон;

8.1.2. мэргэжлийн алдаа гаргасан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол;

8.1.3 эрх бүхий хууль, хяналтын байгууллагын шийдвэрийг үндэслэн.

8.2. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг гээгдүүлсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн бол тухайн хүний хүсэлтийг нь үндэслэн Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр нөхөн олгож болно.

8.3. Мэргэшлийн зэргийн үнэмлэх нөхөн олгох тохиолдолд малын эмч, мэргэжилтэн дараах материалыг бүрдүүлэн, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт гаргана:

8.3.1. мэргэшлийн зэргийн үнэмлэхийг гээгдүүлсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн шалтгааныг тодорхой бичсэн өргөдөл;

8.3.2. гээгдүүлсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн үнэмлэхийг хэвлүүлэх бодит зардлын төлбөрийг төлсөн санхүүгийн баримт.

8.4. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг нөхөн олгож буй тохиолдолд шалгалтад орохгүй ба шинээр олгож буй үнэмлэхийн баруун дээд хэсэгт “Нөхөн олгов” гэж бичиж, олгоно.

8.5. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг хуурамчаар үйлдэх, бусдад дамжуулан ашиглахыг хориглоно.

### **Ес. Бусад зүйл**

9.1. Мэргэжлийн зэргийн сарын нэмэгдлийн хэмжээг “Ахлах” зэрэгтэй малын эмч, мэргэжилтэнд албан тушаалын цалингийн 10 хувиар, “Тэргүүлэх” зэрэгтэйд 15 хувиар, “Зөвлөх” зэрэгтэйд 20 хувиар тус тус тогтоон тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд байгууллагаас нь олгоно.

9.2. Мэргэшлийн зэрэг горилогчдын сургалтын төлбөр, мэргэшлийн зэргийн үнэмлэх, зөвлөх мэргэжилтний энгэрийн тэмдэг, тамга хийлгэх зардлыг тухайн малын эмч, мэргэжилтэн хариуцна.

9.3. Мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулахтай холбоотой зардлыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

### **Арав. Хариуцлага**

10.1. Энэхүү журмыг зөрчсөн Мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, мэргэжлийн сургалт хийх байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, шалгалтын комисс, малын эмч, мэргэжилтэнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----